



ТАВАНТОЛГОЙ ХК

“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 35

Өмнөговь аймаг

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэхь заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 14 цагт компанийн төв байрны хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
  - 2.1 Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах
  - 2.2 Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
  - 2.3 Компанийн 2021 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2022 оны ногдол ашгийг хуваарилах тухай
  - 2.4 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай
  - 2.5 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийн тухай
  - 2.6 Бусад
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 03 дүгээр сарын 21-ний өдрөөр тогтоосугай.
4. “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох баримт бичгүүдийн хамт 2023 оны 03 дугаар сарын 03-ний өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын хөрөнгийн бирж-д хүргүүлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг хавсралт 1-р баталж, Санхүүгийн Зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу олон нийтэд зарласугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичгийн жагсаалтыг хавсралт 2-р баталж, энэхүү баримт бичгийг 2023 оны 3 дугаар сарын 14-ний өдөр бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.

7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах саналын хуудсыг хавсралт 3-р баталж саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2023 оны 04-р сарын 20-ны өдрийн 17 цаг хүртэл хүлээн авахаар тогтоосугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Б.Түвшинбаярыг томилсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Ч.Төрмандах, гишүүдээр Ж.Доржсүрэн, Б.Мөнгөнсүх нарыг тус тус томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн гишүүн Г.Цог-Өрнөхийг томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдон гарах зардлыг компанийн үйл ажиллагааны зардлаас гаргахыг Гүйцэтгэх удирдлага, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч /П.Сайнзориг/-т зөвшөөрсүгэй.

12. Ээлжит хурлыг цахим хэрэгсэл, зайны технологи ашиглах талаар эрх бүхий, мэргэжлийн байгууллагатай зөвшилцөн ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулахыг комиссын дарга /Г.Цог-Өрнөх/, Гүйцэтгэх удирдлага, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч / П.Сайнзориг/-т нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ТҮВШИНБАЯР

Санхүүгийн зохицуулах хорооны  
2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн  
377 дугаар тогтоолоор баталсан  
“Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн  
хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралт

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“Тавантолгой” Хувьцаат компани
Хаяг:	Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-Овоо баг, Компанийн төв байр
Хурал хуралдах өдөр, цаг:	2023 оны 04 сарын 21-ны өдрийн 14 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-Овоо баг, Компанийн төв байр, Хурлын танхим
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2023 оны 02 сарын 27
Олон нийтэд зарлах огноо:	2023 оны 03 сарын 03, 2022 оны 03 сарын 21
Бүртгэлийн өдөр:	2023 оны 03 сарын 21
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасан хугацаанд буюу 2023 оны 03 сарын 14
Хүргүүлсэн огноо:	Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасан хугацаанд
Хурлын даргын нэр:	Б.Түвшинбаяр
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга: Ч.Төрмандах, Гишүүн :Ж.Доржсүрэн, Э.Мөнгөнсүа
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	
Баримт бичгийн хуудасны тоо:	..... ширхэг
	..... хуудас

### ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Тамга

2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр

**“ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ  
АСУУДЛААР ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС  
САНАЛ АВАХ ХУУДАС**

“Тавантолгой” ХК

Компаний хурлын танхим, 2023 оны 04-р  
сарын 21-ны өдөр 14.00 цаг

Хувьцаа эзэмшигчийн нэр: .....

Регистрийн дугаар: .....

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: ..... ширхэг

№	Санал өгөх асуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан бол таны өгөх санал
1	2022 оны Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах				
2	2022 оны Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, ажлын тайланг хэлэлцэж батлах				
3	2021 оны ногдол ашгийн тайлан, 2022 оны ногдол ашиг хуваарьлах талаар				
4	ТУЗ-ийн гишүүдийг сонгох				
5	ТУЗ-ийн зардлын төсөв батлах тухай				
6	Бусад				

**Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг**

Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол:

Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол:

Иргэний овог, нэр

Хуулийн этгээдийн нэр

.....

.....

Гарын үсэг.....

Улсын бүртгэлийн дугаар.....

Хэрэв итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн өгөх бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлийг дор бичиж итгэмжлэлийг саналын хуудасны хамт ирүүлнэ үү.

Хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлийг бөглөнө үү.

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр

.....

.....

Регистрийн дугаар.....

Гарын үсэг.....

Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:.....

Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр гарын үсэг:.....

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүй-д (доогуур зурах) тооцон тоолсон

Тооллогын комиссын Дарга:.....

Гишүүн:.....

Гишүүн:.....

Хүчингүйд тооцсон шалтгаан.....

.....

Хувьцаа эзэмшигч Та, танд илгээсэн ХЭХ-ын тухай мэдэгдэлд заасан хурлаас гарах шийдвэрийн төсөл болон түүнтэй холбоотой бусад материалтай 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн дотор танилцан энэхүү саналын хуудсыг доор заасны дагуу бөглөнө үү.

**Саналын хуудсыг бөглөх санамж:**

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт (+) эсхүл (√) гэсэн тэмдэглэгээг хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд өмнөх 2 тэмдгийн аль нэгийг, түдгэлзсэн бол түдгэлзсэн гэсэн нүдэнд өмнөх 2 тэмдгийн аль нэгийг, татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэнд өмнөх 2 тэмдгийн аль нэгийг тэмдэглэнэ.
2. Хэрэв татгалзсан бол та тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөлд өгөх өөрийн саналаа холбогдох хэсэгт бичнэ үү.
3. Засварласан, балласан, залруулгатай эсхүл давхар тэмдэглэгээний аль нэгийг хийсэн санал авах хуудас хүчингүйд тооцогдоно.
4. Хэрэв та Саналын хуудаст энэхүү санамжийн 1-т заасан тэмдэглэгээний аль нэгийг хийгээгүй бол Түдгэлзсэн-д тооцно.
5. Хэрэв та хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол энэхүү санал авах хуудсанд саналаа тэмдэглэн, өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниараа дамжуулан 2023 оын 04-р сарын 20-ны өдрийн 17:00 цагаас өмнө компанид ирүүлсэн байхыг анхаарна уу.
6. Саналын хуудсыг хурлын үеэр Тооллогын комисс нэгтгэсэн дүнг гаргахаас өмнө бөглөж ирүүлсэн байна. Хурал 2023 оын 04-р сарын 21-ны өдрийн 14:00 цагт компанийн байранд болно.

**“ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ  
АСУУДЛААР ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС  
САНАЛ АВАХ ХУУДАС**

“Тавантолгой” ХК

Компаний хурлын танхим, 2023 оны  
04-р сарын 21-ны өдөр 14.00 цаг

Санал хураах арга: **Кумулятив**

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 09 сарын 09-ны өдрийн 880 тоот тогтоолоор шинэчлэн баталсан журмын дагуу саналаа өгнө. Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байна. Хувьцаа эзэмшигч энэ журмын 2.1-д заасан саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Хувьцаа эзэмшигчийн овог нэр.....

Регистрийн дугаар.....

Эзэмшиж буй тоо.....

Саналын тоо: .....

Санамж: Та өөрийн хувьцааны тоог 9-р үржүүлэн саналын тоог гаргах бөгөөд таны өгсөн саналын нийт дүн уг тоотой тэнцүү байх ёстойг анхаарна уу. Хэрэв саналын тоо болон өгсөн саналын тоо зөрсөн тохиолдолд таны санал хүчингүйд тооцогдох болно.

№	ТУЗ-д нэр дэвшигчийн эцгийн нэр, өөрийн нэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
<b>Ердийн гишүүн</b>				
1				
2				
3				
4				
5				
6				
<b>Хараат бус гишүүн</b>				
7				
8				
9				

Гарын үсэг.....

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүй-д (доогуур зурах) тооцон тоолсон

Тооллогын комиссын

Дарга:.....

Гишүүн:.....

Гишүүн:.....

Хүчингүйд тооцсон шалтгаан.....

Хувьцаа эзэмшигч Та танд илгээсэн ХЭХ-ын тухай мэдэгдэлд заасан хурлаас гарах шийдвэрийн төсөл болон түүнтэй холбоотой бусад материалтай 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн дотор танилцан энэхүү саналын хуудсыг доор заасны дагуу бөглөнө үү.

**Саналын хуудсыг бөглөх санамж:**

1. Засварласан, балласан, залруулгатай эсхүл давхар тэмдэглэгээний аль нэгийг хийсэн санал авах хуудас хүчингүйд тооцогдоно.

2. Хэрэв та хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол энэхүү санал авах хуудсанд саналаа тэмдэглэн, өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниараа дамжуулан 2023 оын 04-р сарын 20-ны өдрийн 17:00 цагаас өмнө компанид ирүүлсэн байхыг анхаарна уу

3. Саналын хуудсыг хурлын үеэр Тооллогын комисс нэгтгэсэн дүнг гаргахаас өмнө бөглөж ирүүлсэн байна. Хурал 2023 оын 04-р сарын 21-ны өдрийн 14:00 цагт компанийн байранд болно.

## “ТАВАНТОЛГОЙ” ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Тавантолгой” ХК-ийн 2023 оны 02 дүгээр сарын 27-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 35 тоот тогтоолоор компанийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 14:00 цагт хуралдуулахаар болсон тул нийт хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

**Хурлын огноо, цаг:** 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 14:00 цагт

**Хуралдах газар:** Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн төв,  
“Тавантолгой” ХК-ийн төв байр

**Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн**

**нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:** 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдөр

**Хурлаар хэлэлцэх асуудал**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах
2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайлан
3. Компанийн 2021 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2023 оны ногдол ашгийг хуваарилах тухай
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөв батлах тухай
6. Бусад

Хуралтай холбоотой баримт бичигтэй компанийн байранд ирж танилцах боломжтой бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд компанийн байранд болон өөрийн харилцдаг брокер, дилерийн компаниар дамжуулан авч болно.

Хурал зохион байгуулах комисс: Дарга Г.Цог-Өрнөх, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Төрмандах

Холбоо барих утас: 99116049, 99074978

Цахим хаяг: [info@tavantolgoi.mn](mailto:info@tavantolgoi.mn), [turmandakh@tavantolgoi.mn](mailto:turmandakh@tavantolgoi.mn)



ТУЗ-ийн 2023 оны  
02 сарын 27 өдрийн 35 тоот  
тогтоолын хавсралт №2

**“ТАВАНТОЛГОЙ” ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй  
холбогдох баримт бичгийн жагсаалт**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан
3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөөн удирдах зөвлөлийн дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайлан
4. Компанийн 2021 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2022 оны ногдол ашгийг хуваарилах талаар мэдээлэл
5. Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой бусад баримт бичиг

Хуралтай холбоотой баримт бичигтэй компанийн байранд ирж танилцах боложтой бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд компанийн байранд болон өөрийн харилцдаг брокер, дилерийн компаниар дамжуулан авч болно.

Хурал зохион байгуулах комисс: Дарга Г.Цог-Өрнөх, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Төрмандах

Холбоо барих утас: 99116049, 99074978

Цахим хаяг: [info@tavantolgoi.mn](mailto:info@tavantolgoi.mn), [turmandakh@tavantolgoi.mn](mailto:turmandakh@tavantolgoi.mn)